



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/72/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	15
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

СОНГИНО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ВАНЧИНДОРЖ ТАНАА

№ 1302/23

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгино сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгино сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022903

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,501.56	84,715.88
35	БАРАА МАТЕРИАЛ	76,501.56	84,715.88
351	Түүхий эд материал	1,506.00	5,928.19
35110	Тусгай зориулалттай материал	00.00	4,437.69
35130	Эм боох материал	1,506.00	1,490.50
354	Хангамжийн материал	74,995.56	78,787.69
35410	Бичиг хэргийн материал	781.40	1,474.53
35420	Аж ахуйн материал	2,400.30	3,435.45
35440	Түлш, шатах тослох материал	2,745.60	2,745.60
35450	Барилгын засварын материал	00.00	774.00
35460	Хүнсний материал	1,051.24	388.65
35470	Бусад хангамжийн материал	68,017.02	69,969.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	440,305.98	562,974.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	440,305.98	562,974.29
392	Биет хөрөнгө	388,190.60	511,271.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,227.68	346,227.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65,218.06	-97,827.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,500.00	12,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,994.79	-4,557.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,290.05	147,925.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,472.90	-123,198.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,960.59	80,960.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-68,182.21	-72,384.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,607.03	219,370.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	-34,203.55	-35,106.54
39217	Ном	34,676.75	37,360.40
393	Биет бус хөрөнгө	52,115.38	51,702.88
39301	Програм хангамж	2,600.00	2,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,190.63	-1,603.13
39303	Бусад биет бус хөрөнгө	50,706.00	50,706.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	516,807.54	647,690.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	516,807.54	647,690.18
51	Засгийн газрын хувь оролцоо	516,807.54	647,690.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	264,938.01	264,938.01
51101	Өмч: - төрийн	264,938.01	264,938.01
512	Хуримтлагдсан үр дүн	-100,646.70	30,235.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-100,646.70	-100,646.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	130,882.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,516.23	352,516.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	516,807.54	647,690.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	720,716.09	861,455.64
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,808.55	188,062.34
120	Нийтлэг татварын бус орлого	27,808.55	188,062.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,808.55	188,062.34
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,931.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,402.95	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,405.60	169,130.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,907.54	673,393.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	602,305.20	572,312.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	602,305.20	572,312.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,602.34	101,080.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,602.34	101,080.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	751,837.21	730,573.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	751,837.21	730,573.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	681,838.41	698,320.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,125.95	462,558.55
210101	Үндсэн цалин	308,715.63	311,867.47
210102	Нэмэгдэл	115,897.49	121,356.07
210104	Урамшуулал	31,512.83	29,335.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,343.58	61,014.97
210201	Тэтгэврийн даатгал	39,316.32	42,433.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,564.50	4,716.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,634.80	3,736.64
210204	Ажилгүйдлийн даатгал	893.45	920.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,934.50	9,207.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,416.74	100,058.83
210301	Гэрэл, цахилгаан	1,238.94	1,434.39
210302	Түлш, халаалт	86,676.80	98,419.20
210303	Цэвэр, бохир ус	501.00	205.24
2104	Хангамж, бараа материалын зардал	7,885.32	4,918.63
210401	Бичиг хэрэг	1,671.40	562.06
210402	Тээвэр, шатахуун	2,056.97	1,770.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	640.00	800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,516.95	1,786.25
2105	Нормативт зардал	15,371.45	15,893.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	728.13	1,233.70
210502	Хоол, хүнс	14,643.32	14,659.82

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	226.00
210604	Урсгал засвар	00.00	226.00
2107	Томилолт, зочны зардал	506.00	1,467.00
210702	Дотоод албан томилолт	506.00	1,467.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,867.40	1,403.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,717.40	671.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	731.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,321.98	50,780.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,096.90	3,365.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,225.08	47,414.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,998.80	32,252.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,644.55	28,512.86
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,927.00	14,600.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,217.55	13,412.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,354.25	3,739.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,354.25	3,739.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-31,121.13	130,882.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,121.13	130,882.64

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,938.01	352,516.23	(100,646.70)	516,807.54
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	264,938.01	352,516.23	(100,646.70)	516,807.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,938.01	352,516.23	(100,646.70)	516,807.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	130,882.64	130,882.64
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,938.01	352,516.23	30,235.94	647,690.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	703,310.48	692,325.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,402.95	18,931.90
120	Нийтлэг татварын бус орлого	10,402.95	18,931.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,402.95	18,931.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,931.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,402.95	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,907.54	673,393.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	602,305.20	572,312.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	602,305.20	572,312.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,602.34	101,080.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,602.34	101,080.60
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	699,160.48	690,165.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,160.48	690,165.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,161.68	657,912.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,125.95	462,558.55
210101	Үндсэн цалин	308,715.63	311,867.47
210102	Нэмэгдэл	115,897.49	121,356.07
210104	Урамшуулал	31,512.83	29,335.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,343.58	61,014.97
210201	Тэтгэврийн даатгал	39,316.32	42,433.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,564.50	4,716.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,634.80	3,736.64
210204	Ажилгүйдлийн даатгал	893.45	920.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,934.50	9,207.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,602.34	100,058.83
210301	Гэрэл, цахилгаан	1,238.94	1,434.39
210302	Түлш, халаалт	88,862.40	98,419.20
210303	Цэвэр, бохир ус	501.00	205.24
2104	Хангамж, бараа материалын зардал	8,183.47	6,646.91
210401	Бичиг хэрэг	1,268.00	1,255.19
210402	Тээвэр, шатахуун	2,056.97	1,770.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	640.00	800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126.70	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,091.80	2,821.40
2105	Нормативт зардал	12,268.05	15,960.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,204.13	1,082.80

210502	Хоол, хүнс	9,063.93	13,997.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.00	880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000.00
210604	Урсгал засвар	-	1,000.00
2107	Томилолт, зочны зардал	506.00	1,467.00
210702	Дотоод албан томилолт	506.00	1,467.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,867.40	1,403.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,717.40	671.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	731.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,264.90	7,803.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,264.90	7,803.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,998.80	32,252.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,644.55	28,512.86
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,927.00	14,600.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,217.55	13,412.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,354.25	3,739.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,354.25	3,739.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,150.00	2,159.95
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,150.00	2,159.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,150.00	2,159.95
2200	Дотоод эх үүсвэрээр	4,150.00	2,159.95
223001	Бусад хөрөнгө	4,150.00	2,159.95
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,150.00)	(2,159.95)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	677,852.20	673,393.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	677,852.20	673,393.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662,751.60	654,553.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,077.60	462,558.55
210101	Үндсэн цалин	416,918.20	311,867.47
210102	Нэмэгдэл	20,000.00	121,356.07
210104	Урамшуулал	26,159.40	29,335.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,515.40	61,014.97
210201	Тэтгэврийн даатгал	43,992.40	42,433.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,630.70	4,716.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,704.70	3,736.64
210204	Ажилгүйдлийн даатгал	926.10	920.31
210205	Эрүүл мэндийн даатгал	9,261.50	9,207.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,580.60	100,058.83
210301	Гэрэл, цахилгаан	5,216.40	1,434.39
210302	Түлш, халаалт	98,419.20	98,419.20
210303	Цэвэр, бохир ус	945.00	205.24
2104	Хангамж, бараа материалын зардал	8,792.10	7,958.02
210401	Бичиг хэрэг	1,056.80	1,056.35
210402	Тээвэр, шатахуун	2,458.40	1,770.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800.00	800.00
210404	Ном, хэвлэл	1,585.10	1,509.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,891.80	2,821.40
2105	Нормативт зардал	16,102.10	15,960.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,082.80	1,082.80
210502	Хоол, хүнс	14,139.30	13,997.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	880.00	880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.00	1,000.00
210604	Урсгал засвар	1,000.00	1,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,479.50	1,467.00
210702	Дотоод албан томилолт	1,479.50	1,467.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,400.00	731.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,400.00	731.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,804.30	3,804.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,804.30	3,804.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,100.60	15,100.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,100.60	15,100.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,600.60	14,600.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	677,852.20	673,393.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	572,271.60	572,312.70
131001	Улсын төсвөөс санхүүжих	572,271.60	572,312.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,580.60	101,080.60
132001	Орон нутгийн төсвөөс	105,580.60	101,080.60
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.039	0.039
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.023	0.023
620003	Үйлчлэх ажилтан	0.015	0.015

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,931.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,931.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,519.64
2104	Хангамж, бараа материалын зардал	198.84
210401	Бичиг хэрэг	198.84
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	671.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	671.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,649.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,649.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,412.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,412.26
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,412.26

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн №01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сонгино сумын Ерөнхий боловсролын сургууль нь Бага дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, “Сурлагын хоцрогдолгүй бүтээлчээр хамтран суралцаж, зөв төлөвшил эзэмшье” зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь боловсролын системийн байгууллагын хүрээнд дагаж мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 673,393.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,100.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 7,575.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	76,501.56	84,715.88	8,214.3
Үндсэн хөрөнгө	440,305.98	562,974.29	122,668.3
Нийт хөрөнгө	516,807.54	647,690.18	130,882.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	516,807.54	647,690.18	130,882.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	516,807.54	647,690.18	130,882.6

Бараа материалын дансны үлдэгдэл 8,214.3 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал болон аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 122,668.3 мянган төгрөгөөр өссөн нь 2,159.9 мянган төгрөгийн худалдан авалт, 167,922.6 мянган төгрөгийн хандивын орлого, 47,414.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэрэгтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 130,882.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 677,852.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 677,852.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 572,271.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 105,580.6 мянган төгрөгийн нийт 677,852.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 673,393.3 мянган төгрөгийг зарцуулж, 3,739.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд улсын төсвөөс 18,931.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтээс 13,412.2 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшил ажилласны тэтгэмжид, 4,649.5 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд, 198,8.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, 671.3 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээг хугацаанд байршуулсан боловч Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээг 28,291.0 мянган төгрөгөөр мэдээлээгүй зөрчил илэрсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна..

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгөд бүртгэлтэй Си Ти Эс санхүүгийн программын ашиглалтын давуу болон сул талыг одоогийн программтай харьцуулан дүгнэлт гаргаж, дээд шатны байгууллагад хандан шийдвэрлэж зохих арга хэмжээг авч ажилласан эсэхийг шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Засварын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой нийт 28,291.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Залруулга хийгдээгүй байна.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

- ✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээг 28,291.0 мянган төгрөгөөр мэдээлээгүй..*

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ *Шилэн дансны хууль, шилэн дансны мэдээлэл боловсруулах аргачлалын дагуу мэдээллийг үнэн зөв цаг хугацаанд нь мэдээлж хэвших*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Сонгино сумын Ерөнхий боловсролын сургууль	1	28.3							1	28.3
Дүн		1	28.3							1	28.3